



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1/38

Эмээлтөлгөй

Г Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах,  
цэвэрлэх ажил зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай" 3.4.4, 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн, малын халдварт өвчин гарах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, халдвартгүйжүүлэлт хийх ажлыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Малын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Сэг зэм устгалын ажил хариуцсан багийн малчдад мэдээлэл хүргэн зохион байгуулалттай оролцуулахыг багийн Засаг дарга наарт, удирдлага, арга зүйгээр хангаж, чанартай, үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

4.Малын сэг зэм устгах, халдвартгүйжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулагдахад шаардагдах зардлыг холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Д.Азжаргал)-д зөвшөөрсүгэй.

642401055

D/2024on/Zahiramj-2024on-docx

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.



Сумын Засаг даргын *2024* оны *03* дугаар  
сарын *25*-ны өдрийн *9/30* дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**МАЛЫН СЭГ ЗЭМ УСТГАЛЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түмэнжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ч.Цэдэвсүрэн (1 дүгээр багийн Засаг дарга)

Ж.Должинсүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Гарьсоном (3 дугаар багийн Засаг дарга)

Н.Ганжаргал (4 дүгээр багийн Засаг дарга)

Ж.Сүхбаатар (БОХУБайцаагч)

Г.Бат-Эрдэнэ (Байгаль хамгаалагч)

Д.Тайванжаргал (Байгаль хамгаалагч)

Г.Шийрэвсамбуу (Байгаль хамгаалагч)

Б.Болормаа (Малын их эмч)

С.Нанжид (Малын их эмч)

Т.Уранчиимэг (Малын их эмч)

О.Мөнхжаргал (Биеийн тамирын арга зүйч)

Б.Буян-Аривжих (Нярав)

Ц.Ганхуяг (Жолооч)

Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн

Сумын Эрэн хайх, аврах, салбар

Цагдаагийн тасаг

Нарийн бичиг: С.Жаргалсайхан (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Сумын Засаг даргын ..... оны ..... дугаар  
сарын ..... 25 ..... -ны өдрийн ..... A/38 ..... дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

## УДИРДАМЖ



Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах,  
халдвартгуйтгэлийн ажил зохион байгуулах тухай

### Нэг. Зорилго

1.1.Хүн, малын халдварт өвчин гарах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, байгалийн бохирдол багасаж, байгаль орчны экологийн тэнцвэрт байдлыг хангахад оршино.

### Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

2.1.Тус сумын 4 багийн нутаг дэвсгэрийг хамруулан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулна.

### Гурав. Гүйцэтгэх ажил, арга хэмжээ

3.1.Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нар хариуцсан багийн малчдад мэдээлэл хүргэн сэг зэм устгалын ажилд зохион байгуулалттай оролцуулж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа ёгч гарын үсэг зуруулж баталгаажуулах

3.2.Багийн Засаг дарга нар сэг зэм устгалын ажил зохион байгуулах маршрутыг батлуулж, тогтоосон хугацаанд чанар, үр дүнтэй зохион байгуулах

3.3.Малын хүүр, сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, малын хашаа хороо, автомашины зам, худаг уст цэгээс зйттай, үерийн уст автхаарагүй газарт нохой, жижиг махчин амьтан ухаж идэхээргүй нүх ухаж сэг зэмээ хийж, дээр нь халдвартгуйтгэлийн бодис /хлорын шохой цацаж/ булшилна. Шороог нүхний амсраас дээш 1.5 метрээс багагүй байхаар овоолж хөрсөөр хучна.

3.4.Халдвартгуйтгэлд улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанар стандартын шаардлага хангасан, хүн, мал, байгаль орчинд хор хөнөөлгүй бодисыг ашиглах

3.5.Малын сэг зэм тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг цэвэрлэж, халдвартгуйтгэх

### Дөрөв. Тайлагнах

4.1.Малын сэг зэм устгал, халдвартгүйтгэл мэдээг хавсралт маягтын дагуу 7 хоног бүр аймгийн Мал эмнэлгийн газар, БОАЖГ, бусад холбогдох газруудад мэдээлэх